

## Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтийг тооцох заавар

Нэг. Гэмт хэрэгтэй тэмцэх

1.1. Мөрдөн шалгах:

1.1.1. Ирсэн гомдол, мэдээлэл (гэмт хэрэг, зөрчил, бусад)

- Ирсэн гомдол, мэдээллийн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.
- Ирсэн гомдол, мэдээлэл (гэмт хэрэг, зөрчил, бусад)-ийг бүрэн /100 хувь/ бүртгэсэн байна. Хэрэв бүртгэгдээгүй тохиолдол байвал энэ үзүүлэлтийн түвшин 100%-иас буурч үнэлэгдэх ба үнэлгээг дараах байдлаар тооцно.

Жишээ: Тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн гомдол, мэдээллийн тоо 135, бүртгээгүй зөрчлийн тоо 15 байна гэж үзвэл үнэлгээ хувиар:

$$\frac{135}{(135+15)} \times 100\% = 90\%$$

оноогоор:  $90\% \times 0,05 = 4,5$  оноо

Дуудлагад очсон дундаж хугацаа гэдэгт тухайн жилийн нийт дуудлагад очсон хугацааны дундажийг ойлгоно.

Энэ үзүүлэлтийн түвшинг дуудлагад очсон дундаж хугацааг өмнөх оны дуудлагад очсон дундаж хугацаанд харьцуулж хувиар гаргасан дүнг 100%-иас хасч тооцно.

Жишээ: Бодит дундаж хугацаа 20 минут гэж үзвэл үнэлгээ хувиар:

$$\frac{15}{20} \times 100\% = 75,0\%$$

1.1.2. Шалгасан гомдол, мэдээлэлийн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ. Шалгасан гомдол мэдээллийн оноо, хувийг аргачлалаар тооцно:

- Процессын зөрчил гэдэг нь гомдол, мэдээллийг шалгах явцад хуульд заасан үндэслэл, журмыг зөрчсөн зөрчлийг хамааруулан ойлгоно.

Жишээ: Нийт шалгасан гомдол, мэдээллийн тоо 120 процессын зөрчлийн тоо 13 гэж үзвэл үнэлгээ хувиар:

$$100\% - \left( \frac{13 \times 100\%}{120} \right) = 89,1\%$$

оноогоор:  $89,1\% \times 0,05 = 4,4$  оноо

➤ Процесстой холбогдох гомдол гэдэг нь гомдол, мэдээллийг шалгах явцад оролцогчдоос гаргасан үндэслэлтэй гомдлыг хамааруулан ойлгоно.

Жишээ: Нийт шалгасан гомдол, мэдээллийн тоо 120 процесстой холбогдох гомдлын тоо 25 гэж үзвэл үнэлгээ хувиар:

$$100\% - \left( \frac{25 \times 100}{120} \right) = 79,2\%$$

оноогоор:  $79,2\% \times 0,05 = 3,9$  оноо

### 1.1.3 Гомдол мэдээллийн шийвэрлэлт:

Нийт хүлээн авсан гомдол мэдээллийнхээ 90-ээс багагүй хувийг шийдвэрлэхэд үнэлгээ 100 хувь буюу 5 оноо байх бөгөөд 90-ээс бага хувийн шийдвэрлэлттэй дараах байдлаар үнэлнэ.

Жишээ: Гомдол мэдээллийн шийвэрлэлт 86,3% байсан гэж үзвэл үнэлгээ хувиар:

$$\frac{86,3\% \times 100\%}{90\%} = 95,8\%$$

оноогоор:  $95,8\% \times 0,05 = 4,8$  оноо

- Шийдвэрлэсэн гомдол мэдээллээс хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн байдлыг тооцохдоо шийдвэрлэсэн гомдол мэдээллээс шалгуур үзүүлэлтийн босго оноотой харьцуулан бодно.
- Гомдол, мэдээлэл гаргагчид хариу мэдэгдсэн үзүүлэлтийг тооцохдоо шийдвэрлэсэн гомдол мэдээлэлийн тоог шалгуур үзүүлэлтийн хувьтай харьцуулан бодно.

### 1.1.4 Хэрэг бүртгэлт явуулсан хэрэг

- Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ. Хуулийн үндэслэл, журам зөрчигдөөгүй байх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо нийт шалгасан хэргийн тоог гаргасан зөрчлийн тоотой харьцуулан оноо хувийг тооцож бодно.
- Байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой үндэслэл бүхий гомдол гараагүй байх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо нийт шалгасан хэргийн тоог гаргасан гомдлын тоотой харьцуулан оноо хувийг тооцож бодно.

Жишээ: Нийт шалгасан хэргийн тоог гаргасан гомдол мэдээлэл 105, үүний гуравт нь байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой үндэслэл бүхий гомдол гарсан гэж үзвэл үнэлгээ хувиар:

$$100\% - \left( \frac{3 \times 100\%}{105} \right) = 97,2\%$$

оноогоор:  $97,2\% \times 0,05 = 4,8$  оноо

- Хэргийн шийдвэрлэлтийг 90 хувьд хүргэх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо нийт шийдвэрлэсэн хэргийн тоо хувийг шалгуур үзүүлтийн хувьтай харьцуулан тооцож бодно.
- Хуулийн анхны хугацаанд 90-ээс доошгүй хувийг шийдвэрлэсэн шалгуур үзүүлэлтийг тооцохдоо шийдвэрлэсэн хэргийн тоо хувийг шалгуур үзүүлэлтийн хувьтай харьцуулан тооцож бодно.
- Хэрэг бүртгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалж нэмэлт ажиллагаанд буцсан хэрэг нийт хэрэгт эзлэх хувийг тооцохдоо нэмэлт ажиллагаанд буцсан хэргийн тоог нийт шийдвэрлэсэн хэргийн тоотой харьцуулж тооцно.

#### 1.1.5. Мөрдөн байцаалт явуулсан хэрэг

- Мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ.
- Хуулийн үндэслэл, журам зөрчигдөөгүй байх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо нийт шалгасан хэргийн тоог гаргасан зөрчлийн тоотой харьцуулан оноо хувийг тооцож бодно.

$$100\% - \left( \frac{3 \times 100\%}{105} \right) = 97,2\%$$

- Байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой үндэслэл бүхий гомдол гараагүй байх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо нийт шалгасан хэргийн тоог гаргасан гомдлын тоотой харьцуулан оноо хувийг тооцож бодно.

$$100\% - \left( \frac{15 \times 100\%}{105} \right) = 85,7\%$$

- Хэргийн шийдвэрлэлтийг 80 хувьд хүргэх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо нийт шийдвэрлэсэн хэргийн тоо хувийг шалгуур үзүүлтийн хувьтай харьцуулан тооцож бодно.
- Хуулийн анхны хугацаанд 90-ээс доошгүй хувийг шийдвэрлэсэн шалгуур үзүүлэлтийг тооцохдоо шийдвэрлэсэн хэргийн тоо хувийг шалгуур үзүүлэлтийн хувьтай харьцуулан тооцож бодно.
- Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанаас шалтгаалж нэмэлт ажиллагаанд буцсан хэрэг нийт хэрэгт эзлэх хувийг тооцохдоо нэмэлт ажиллагаанд буцсан хэргийн тоог нийт шийдвэрлэсэн хэргийн тоотой харьцуулж тооцно.

#### 1.1.6 Эзэнгүй хэрэг

Эзэнгүй хэргийн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ.

Гэмт хэргийн илрүүлэлтийг тооцохдоо тухайн оны нийт эзэнгүй хэргийн тоог илрүүлсэн хэргийн тоотой харьцуулж илрүүлэлтийн хувийг гаргана.

$$/ 5,3 \times 100/9,1 = 58,3 - 100 = 41,7/$$

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ.

1.2.1. Эргүүл хийсэн хүн/цаг нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ.

Эргүүлийн ажиллагаагаар урьдчилан сэргийлж, таслан зогсоосон, илрүүлсэн хэрэг, зөрчлийн тоо урьд оноос өссөн байх.

Нийт гэмт хэрэгт эзлэх гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн хувь өмнөх оноос буурсан байх

1.2.2 Галт зэвсгийн хяналт: Олгосон зөвшөөрлийн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ.

Шалгасан аж ахуйн нэгж байгууллагын тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ.

Зөрчил илрүүлж дутагдлыг бүрэн арилгуулсан байх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо тухайн онд арилгуулсан зөрчлийг илрүүлсэн зөрчилтэй харьцуулна.

Галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэг зөрчлийн гаралт буурсан байх.

Нуугдмал бүртгэлгүй галт зэвсгийн илрүүлэлтийн хувийг нэмэгдүүлсэн байх.

1.2.3. Захиргааны хяналт:

Захиргааны хяналтанд байгаа нийт хүний тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт, түүний өсөлт, бууралтыг илтгэнэ.

Хяналтанд байгаа хүнээс дахин гэмт хэрэг зөрчил үйлдээгүй байх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо хяналтанд байгаа нийт хүний тоог гэмт хэрэг зөрчил үйлдсэн хүний тоотой харьцуулна.

Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд бичсэн мэдэгдэл, шаардлагын биелэлт, үр дүнг бүрэн тооцсон байх шалгуур үзүүлэлтийг тооцохдоо бичсэн мэдэгдэл шаардлагын тоог биелэлт үр дүнг нь тооцсон мэдэгдэл шаардлагын тоотой харьцуулна.

## Хоёр. Нийтийн хэв журам хамгаалах

2.1 Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх

- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд цагдаагийн байгууллагаас туслалцаа хүссэн, туслалцаа үзүүлсэн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд туслалцаа үзүүлсэн

нь шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу 100 хувь буюу бүрэн үзүүлсэн байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно.

Нийт туслалцаа хүссэн тоо (120)-нд туслалцаа үзүүлсэн тоо (110)-г харьцуулан пропорцийн аргаар ( $110 \times 100\% / 120 = 91,6\%$ ) тооцож, оноо ( $91,6\% \times 0,05 = 4,5$  оноо)-нд шилжүүлнэ.

2.2. Зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо бүртгэл хөтөлсөн байдал

- Зам тээврийн ослын шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд 100 хувь бүртгэсэн байх, бүртгээгүй тухай зөрчил гараагүй байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно:

Тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн зам тээврийн ослын тоо (112) + тухайн онд бүртгээгүй ослын тоо (8) = нийт зам тээврийн ослын тоог ( $112 + 8 = 120$ ) гаргаж, тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн зам тээврийн ослын тоонд ( $112 \times 100 / 120 = 93,3\%$ ) харьцуулан хувийг тооцож, оноо ( $93,3\% \times 0,05 = 4,6$  оноо)-нд шилжүүлнэ.

- **Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн** шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд 100 хувь бүртгэсэн байх, бүртгээгүй тухай зөрчил гараагүй байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно:

Тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо (170) + тухайн онд бүртгээгүй ослын тоо (40) = нийт Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоог ( $170 + 40 = 210$ ) гаргаж, тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоонд ( $170 \times 100 / 210 = 80,9\%$ ) харьцуулан хувийг тооцож, оноо ( $80,9\% \times 0,05 = 4$  оноо)-нд шилжүүлнэ.

-**Нас барсан хүн** гэдэг шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд 100 хувь бүртгэсэн байх, бүртгээгүй тухай зөрчил гараагүй байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно:

Тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн нас барсан хүн тоо (7) + тухайн онд бүртгээгүй нас барсан хүний тоо (1) = нийт нас барсан хүний тоог ( $7 + 1 = 8$ ) гаргаж, тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн нас барсан хүний тоонд ( $7 \times 100 / 8 = 87,7\%$ ) харьцуулан хувийг тооцож, оноо ( $80,9\% \times 0,05 = 4,4$  оноо)-нд шилжүүлнэ.

➤ **Гэмтсэн хүн** гэдэг шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд 100 хувь бүртгэсэн байх, бүртгээгүй тухай зөрчил гараагүй байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно:

Тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн гэмтсэн хүн тоо (110) + тухайн онд бүртгээгүй гэмтсэн хүний тоо (10) = нийт гэмтсэн хүний тоог ( $110 + 10 = 120$ ) гаргаж, тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн гэмтсэн хүний тоонд ( $110 \times 100 / 120 = 91,6\%$ ) харьцуулан хувийг тооцож, оноо ( $91,6\% \times 0,05 = 4,5$  оноо)-нд шилжүүлнэ.

➤ **Эд материалын хохирол** гэдэг шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд 100 хувь бүртгэсэн байх, бүртгээгүй тухай зөрчил гараагүй байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно:

Тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн эд материалын хохиролын мөнгөн дүнг (110.000) + тухайн онд бүртгээгүй эд материалын хохиролын мөнгөн дүнг (10.000) = нийт эд материалын хохиролын мөнгөн дүнг (110.000 + 10.000 = 120.000) гаргаж, тухайн онд мэдээллийн санд бүртгэсэн эд материалын хохиролын мөнгөн дүнд ( $110.000 \times 100 / 120.000 = 91,6\%$ ) харьцуулан хувийг тооцож, оноо ( $91,6\% \times 0,05 = 4,5$  оноо)-нд шилжүүлнэ.

**2.3. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжилалт**

- Сураггүй алга болсон хүн гэдэгт Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгасан болон бусад байдлаар эрэн сурвалжилж шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу эрэн сурвалжилж байгаа болон шийдвэрлэлтийн талаар Цагдаагийн байгууллагын мэдээллийн "ASAP" нэгдсэн санд 100 хувь бүртгэсэн байх, бүртгээгүй тухай зөрчил гараагүй байх, нийт эрэн сурвалжилтанд олж тогтоосон эзлэх хувийг өмнөх оноос ахиулсан байх, олж тогтооход шаардлагатай ажиллагааг бүрэн хийсэн байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно:

- Сураггүй алга болсон хүний тоо нь урд оны үлдэгдэл дээр (80) + тухай онд бүртгэсэн сураггүй алга болсон хүний тоо (110)+ тухайн онд бүртгээгүй зөрчлийн тоо(10) = нийт сураггүй алга болсон хүний тоог ( $80+110+10=200$ ) гаргаж, тухайн онд мэдээллийн санд бүртгээгүй зөрчлийн тоог тухайн онд бүртгэсэн сураггүй алга болсон хүний тоонд ( $10 \times 100 / 110 = 90,9\%$ ) харьцуулан хувийг тооцож, оноо ( $90,9\% \times 0,05 = 4,5$  оноо)-нд шилжүүлнэ.

- Оргодол гэдэгт Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар эрэн сурвалжилж шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу эрэн сурвалжилж байгаа болон шийдвэрлэлтийн талаар Цагдаагийн байгууллагын мэдээллийн "ASAP" нэгдсэн санд 100 хувь бүртгэсэн байх, бүртгээгүй тухай зөрчил гараагүй байх, нийт эрэн сурвалжилтанд олж тогтоосон эзлэх хувийг өмнөх оноос ахиулсан байх, олж тогтооход шаардлагатай ажиллагааг бүрэн хийсэн байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно:

Оргодолын тоо нь урд оны үлдэгдэл дээр (80) + тухай онд бүртгэсэн сураггүй алга болсон хүний тоо (110)+ тухайн онд бүртгээгүй зөрчлийн тоо (10) = нийт сураггүй алга болсон хүний тоог ( $80+110+10=200$ ) гаргаж, тухайн онд мэдээллийн санд бүртгээгүй зөрчлийн тоог тухай онд бүртгэсэн сураггүй алга болсон хүний тоонд ( $10 \times 100 / 110 = 90,9\%$ ) харьцуулан хувийг тооцож, оноо ( $90,9\% \times 0,05 = 4,5$  оноо)-нд шилжүүлнэ.

#### Хоёр. Нийтийн хэв журам хамгаалах

2.1 Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх

- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд цагдаагийн байгууллагаас туслалцаа хүссэн, туслалцаа үзүүлсэн тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.

- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд туслалцаа үзүүлсэн нь шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн дагуу 100 хувь буюу бүрэн үзүүлсэн байх бөгөөд оноо, хувийг гаргахдаа дараах аргачлалаар тооцно.

Нийт туслалцаа хүссэн тоо (120)-нд туслалцаа үзүүлсэн тоо (110)-г харьцуулан пропорцийн аргаар ( $110 \times 100\% / 120 = 91,6\%$ ) тооцож, оноо ( $91,6\% \times 0,05 = 4,5$  оноо)-нд шилжүүлнэ.

### Гурав. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах

3.1. Дипломат төлөөлөгчийн газрын хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн байдлыг дүгнэхдээ хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн өмнөх оны гүйцэтгэлийг тухайн оны гүйцэтгэлтэй харьцуулан өсөлт бууралтаар нь оноо болон хувиар дүгнэнэ.

$$(85 \times 100\% / 95 = 89,4\%), (89,4\% \times 0,05 = 4,47 \text{ оноо})$$

3.1.1. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.

3.1.2. Шалган нэвтрүүлсэн хүн, тээврийн хэрэгсэл, бараа материалын тоо нь урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.

3.2. Улсын онц чухал объект болон бусад объект хамгаалах, шаардлагатай үед зарим объектийг түр хугацаагаар хамгаалах үүрэг гүйцэтгэсэн байдлыг дүгнэхдээ объектод гарсан нийт зөрчлөөс алба хаагчын илрүүлсэн хувь 90-ээс доошгүй илрүүлсэн байхаар харьцуулж оноо хувийг гаргана.

Нийт зөрчлийн тоо 60 байхад 51 зөрчлийн алба хаагч илрүүлж 9 зөрчлийн байгууллагын дотоод хяналтаар илрүүлсэн гэж үзэж харьцуулахад ( $60 \times 100\% / 51 = 85\%$ ), ( $85\% \times 0,05 = 4,25$  оноо)

3.1.3. Үүрэг гүйцэтгэх хугацаанд алба хаагчаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийн өмнөх оны гүйцэтгэлийг тухайн оны гүйцэтгэлтэй харьцуулан өсөлт бууралтаар нь оноо болон хувиар дүгнэнэ.

3.2. Зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн байдал урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.

3.2.1. Үүрэг гүйцэтгэх хугацаанд алба хаагчаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийн өмнөх оны гүйцэтгэлийг тухайн оны гүйцэтгэлтэй харьцуулан өсөлт бууралтаар нь оноо болон хувиар дүгнэнэ.

3.2.2. Хамгаалуулагч байгууллагаас гаргасан үндэслэлтэй гомдлын өмнөх оны гүйцэтгэлийг тухайн оны гүйцэтгэлтэй харьцуулан өсөлт бууралтаар нь оноо болон хувиар дүгнэнэ.

3.3. Байгалийн гамшиг, үйлдвэрийн осол, гал түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэм

сахиулахад оролцсон байдал урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.

3.3.1. Дэглэмийн үед гарсан нийт зөрчлийг алба хаагчийн илрүүлсэн зөрчилтэй харьцуулж 90-ээс доошгүй хувийг алба хаагч илрүүлсэн байхаар шалгуур үзүүлэлт гаргаж оноо болон хувиар дүгнэнэ.

3.4. Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц байдал зарласан үед дэг журам сахиулахад оролцсон байдлыг дүгнэхдээ байгууллагын нийт алба хаагчдын тоог дадлага сургуулалтад оролцсон алба хаагчийн тоотой харьцуулж дүгнэнэ.

3.5. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэсэн байдлыг дүгнэхдээ нийт урьчдиглан сэргийлэх үзлэг шалгалтыг илрүүлсэн зөрчилтэй харьцуулахад өмнөх онд 11,1 хувийн илрүүлэлттэй байсан бол энэ онд 13,1 хувь болж өссөн тул оноо хувийг бүрэн дүгнэнэ.

3.6.1. Төрийн тусгай хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн алба хаагчийн бэлэн байдлыг хангаагүй /агсамж/ зөрчлийг дүгнэхдээ зөрчил гаргасан алба хаагчдын тоог хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн нийт алба хаагчдын тоонд харьцуулж оноо, хувийг дүгнэнэ.

3.7. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалахад оролцсон байдлыг дүгнэхдээ нийт хамгаалалтыг, хамгаалалтын үед гарсан зөрчилтэй харьцуулж оноо, хувийг дүгнэнэ.

3.7.1. Үүрэг гүйцэтгэх хугацаанд алба хаагчаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийн өмнөх оны гүйцэтгэлийг тухайн оны гүйцэтгэлтэй харьцуулан өсөлт, бууралтаар нь оноо болон хувиар дүгнэнэ.

3.8. Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн байдлыг дүгнэхдээ нийт хамгаалалтын тоог хамгаалалтын үед гарсан зөрчилтэйгээ харьцуулж оноо хувиар дүгнэнэ.

3.8.1. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн алба хаагчийн бэлэн байдлыг хангаагүй /агсамж/ зөрчил гаргасан алба хаагчдын тоог хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн нийт алба хаагчдын тоонд харьцуулж оноо, хувийг дүгнэнэ.

3.9. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдал урьд оны болон энэ оны статистик үзүүлэлт болон өсөлт, бууралтыг илтгэнэ.

3.9.1. Албадан тараах ажиллагааны үед бэртэж гэмтсэн иргэдийг жагсагчидын тоотой харьцуулж бэртэж гэмтсэн алба хаагчдыг ажилсан хүний тоотой харьцуулж оноо хувиар дүгнэнэ. Учирсан хохирлыг өмнөх оныхтой харьцуулж оноо хувиар дүгнэнэ.

3.10. Гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа явуулах журмын биелэлтэд хяналт тавьсан байдлыг дүгнэхдээ бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагуудыг хяналт шалгал хийсэн тоо хувьтай харьцуулж оноо хувийг тооцно.

Мөн илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэсэн хувиар тооцно.